



**ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ
СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/120

Улаанбаатар хот

**Өндөржүүлсэн бэлэн байдалд
шилжин ажиллах тухай**

Монгол Улсын ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар зарлиг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11.2, 11.3.3 дахь заалтыг үндэслэн Монголын Улсын онцгой комисс, Эрчим хүчний яамны 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн шуурхай хуралдаанаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, шугам тоноглолын найдвартай ажиллагааг хангах зорилгоор компанийн хэмжээнд 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд COVID-19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний албан даалгаврыг хавсралт ёсоор баталсугай.

3. 220,110 кВ-ын шугам тоноглолын тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллах, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээ авах, гамшгаас хамгаалах орон тооны бус мэргэжлийн ангийн болон хоол хүнс, хувцас, унаа, шатахуун, мөнгө, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг тус тус хангаж ажиллахыг штабын дарга Б.Дашдаваад үүрэг болгосугай.

4. Нийт ажилтнууд компани, салбарын захиргааны зөвшөөрөлгүйгээр өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн хугацаанд ажил, амралтын өдрүүдэд хот, хөдөө орон нутагт явахгүй байх, сонор сэрэмж, хариуцлага сахилга батыг дээшлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг хэлтэс, салбарын дарга нарт даалгасугай.

5. Тушаалын биелэлтэд хяналт тавьж хэрэгжүүлж ажиллахыг тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженер Б.Дашдаваад даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.НЯМСАМБУУ

171200503

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2020 оны
0.3 дугаар сарын 31-ны өдрийн 11/20
дугаар тушаалын хавсралт



COVID-19 ВИРУСИЙН ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ АЛБАН ДААЛГАВАР №01

Нэг. Хүн хүч, зохион байгуулалтын чиглэлээр:

- Гамшгаас хамгаалах орон тооны бус байнгын штабын үйл ажиллагааг эрчимжүүлж, 2020 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн “Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, илэрсэн тохиолдолд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний дагуу ажиллах, биелэлтийг заагдсан хугацаанд хэрэгжүүлэн ажиллах,
- Онцгой нөхцөл байдал үүсэж, аваар саатал гарсан тохиолдолд хүн хүч, машин механизмын бэлэн байдлыг хангаж ажиллах,
- Нийт ажилтанд зөвлөмжийн дагуу ээлжит бус зааварчилгыг халдвар хамгаалалтын өндөржүүлсэн нөхцөлд өгч, ажлын байруудад хяналт шалгалтыг тогтмол явуулах,
- Салбаруудын гамшгаас хамгаалах орон тооны бус зөвлөл, штабууд өдөр бүрийн 16.00 цаг багтаан мэдээллийг ХМХ-т ирүүлэх
- Онцгой нөхцөл байдал үүссэн нөхцөлд мэдээллийг шуурхай дамжуулах
- Зарлан дуудах схемийн дагуу хүн, хүчний бие бүрэлдэхүүний цугларалтын байдлыг хангаж ажиллах
- Мэдээлэл дамжуулах холбоо, мэдээллийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах, ээлжит бус үзлэг, үйлчилгээг явуулах
- Халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх талаар явуулсан 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01/130 тоот зөвлөмжийн дагуу ажиллах
- Вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор компанийн хэмжээнд оффис, дэд станцууд дахь ажилтнуудын болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тавих хяналтыг чангатгах
- Зайлшгүй шаардлагатай, онцгой нөхцөлд чөлөө авах, ажлын цагаар гадуур ажиллах бол захиргаанд зайлшгүй мэдэгдэж рапортод тэмдэглүүлэх
- Олон нийтийг хамарсан арга хэмжээ, хурал зөвлөгөөн хийхгүй байх
- Ажилтнуудын амны хаалт, ариутгалын бодисын нөөц бэлдэх
- Технологийн болон хөдөлмөрийн сахилга батыг дээшлүүлэх
- Мэдээ, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг хангаж ажиллах
- Цахим үйлчилгээ нэвтрүүлэх, гадны хүн нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авах

Хоёр. Дэд станц, ажлын байр, контор тасалгаа өрөөнүүдэд хийх ариутгалын чиглэлээр:

- Ажлын байруудын цэвэрлэгээ, ариутгалын хуваарь гаргаж, тогтмол хийх
- Дэд станц, конторын байруудад гаднаас орж гарах цэгүүдэд гар ариутгалын бодисыг байрлуулж, гаднаас ирж байгаа хүмүүсийн гарыг заавал ариутгаж нэвтрүүлэх

- Ажлын байр, нэвтрэх цэгүүдийг тогтмол ариутгах, амны хаалтгүй иргэдийг нэвтрүүлэхгүй байх

Гурав. Хувийн ариун цэвэр хяналтын чиглэлийн зөвлөмж

- Гадуур гарахдаа тогтмол бээлий өмсөх, аль болох хаалганы бариулаас гараараа барихгүй байх, гаднаас орж ирээд бээлий, малгай, ороолтоо угаах
- Гараа бохирлогдсон нөхцөлд савантай бүлээн усаар тогтмол угааж занших, бусад тохиолдолд санитол, санитас зэрэг гар ариутгах уусмалаар ариутгах
- Ам, нүдэндээ гар хүрэхгүй, нухахгүй байх, аль болох хүнтэй гар барихгүй мэндлэх
- Хаалга онгойлгох, цахилгаан шатанд суух үед аль болох гараараа гадаргуун дээр хүрэхгүй байх
- Амны хаалт тогтмол хэрэглэх бөгөөд мэс заслын нэг удаагийн амны хаалтыг 2-4 цаг орчимд солих, N95 стандартын амны маск нь дэгдэлтийн үед 3 хоног, энгийн үед 5 хоног хэрэглэдэг тул амны маскийг удаан хугацаагаар зүүхгүй байх
- Хэрэглэсэн амны маскийг уутанд хийж, аюулгүй болгож хаях ба хогийн саванд удаан хадгалахгүй байх
- Боломжтой бол гэртээ болон албан тасалгааныхаа цонх, хаалгыг нээж агаар сэлгэх, тасалгааны температурыг хэвийн хэмжээнээс бууруулахгүй байх
- Мах махан бүтээгдэхүүн /тахиа, гахай/ бүрэн гүйцэт болгож, хүнсэндээ хэрэглэх
- Хоолны газарт олноороо цуглаж, нэг тавагнаас хооллохгүй байх, Ази хоолноос аль болох татгалзах, гэр бүлийн гишүүд өөрсдийн халбага, сэрээ, аяга, таваг, алчууртай болох
- Гар хүрдэг эд хөрөнгөө өдөр тутам спирт болон ариутгах бодисоор тогтмол цэвэрлэх
- Ханиалгаж байгаа болон өвдсөн хүнтэй аль болох харилцахгүй байх, хэрэв зайлшгүй тохиолдолд гэр бүлийн гишүүдээ халамжилж байвал нэг удаагийн бээлий, амны хаалтыг тогтмол хэрэглэх
- Вирус нь нүдний салстаар дамжин халдварладаг тул аль болох нүдний шил тогтмол зүүх
- Хувийн ариун цэврийн хяналтын талаар уг зөвлөмжийг бүх ажлын байруудад хүний нүдэнд харагдахуйц газар байрлуулах
- Дархлаа дэмжих дасгал хөдөлгөөнийг тогтмол хийх

ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙН ХЭЛТЭС